



БЭЛГЭДЛИЙН ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

М.Нарантуяа²⁰

А.Өлзийнаран²¹

Abstract: *Literary tools such as symbols allow for the recognition of a country's mentality and thinking. The experience and lessons learned from these examples that by studying numbers and religious symbols of the literature, it is possible to translate them without losing the essence, implication, reason, and correlation of the symbols. Therefore, symbols represent the writer's conception through abstract and realistic thinking, as they reflect the differences and features of lifestyle, tradition, religion, and culture. It is important to pay attention to the relevance and translation of literary translation, which is a subject of the literary study.*

Түлхүүр үг: *бэлгэдэл, утга шилжих хэлбэр, далд утга, ухамсар сэтгэхүй, дүр дүрслэл*

Уран зохиолын орчуулга бие даасан орчуулгын төрөл учраас тухайн ард түмний аж амьдрал, ахуй соёл, оюун санаа сэтгэлгээг цогцоор тусгасан уран сайхны бүтээл билээ. Хүн байгалийн болон нийгмийн бүтээгдэхүүн учраас өсөж хүмүүжсэн орчин, амьдарч буй цаг үеийн өөрчлөлт хувьсал, бусад олон хүчин зүйлс хувь хүнд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Зохиолч нь зохиолынхоо дүрүүдэд тухайн цаг үе, нийгмийн нийтлэг төрх, онцлог шинж байдлыг тусган туурвидаг. Энэ нь тэр үеийн зан заншил, хуулиар сэтгэж, бодож, ярьж, хүсэж хөдөлмөрлөнө гэсэн хэрэг бөгөөд “зохиолчийн үзэл санааны хүчээр нийгмийн шинж төлөв байдлыг тусгасан хэрэг мөн” (Байгалсайхан, 1998, хууд. 67) гэж тэмдэглэсэн. Зохиолч уран бүтээлдээ хүмүүсийн хувь заяаг хүний амьдралын жам ёсоор өгсөж дээшлэх, уруудан доройтох диалектик харилцан холбоонд нь дүрслэн үзүүлдэг. Ингэхдээ бэлгэдлийг хэрхэн ашигласныг тодруулахыг зорьсон болно.

Эртний грекийн тэмдэг, онцгойлон таних тэмдэг гэсэн үгнээс гаралтай бэлгэдэл (symbolon) хэмээх нэр томъёо нь утга зохиол судлалд нэг талаас уран дүрийн нөгөө талаас тэмдэг, төлөөллийн шинж чанарыг хадгалсан урлаг, уран сайхан, гоо зүйн онцгой нэгэн нийлэг ай болон хэрэглэгддэг юм. Өргөн утгаараа бол өөрийнхөө гүйцэтгэх үүрэгт тэмдгийн бүх шинжийг ашигласан уран сайхны дүр бөгөөд, мөн уран дүрийн шавхагдашгүй олон утга санаа, зохион байгууламжийг биедээ тааруулсан тэмдэг юм. (Байгалсайхан, 1998, хууд. 137)

“Бэлгэдэл бол өргөн утгаараа бүхий л дохиолог хүчин зүтгэлд нь авч үзсэн дүр мөн бөгөөд шавхагдашгүй олон утга аяс, амьдлаг цогцос бүхий дохио мөн билээ. Иймд аливаа бэлгэдэл болгон дүр байдаг бөгөөд дүр болгон ямар нэг хэмжээгээр бэлгэдэл байдаг” (Дулам, 1999, хууд. 5) гэж өгүүлжээ. “Бэлгэдэл нь хийсвэр ойлголт бөгөөд сэтгэхүйд тулгуурлан бодит байдлын тодорхой юм,

²⁰ МУИС, ШУС, дэд профессор, доктор

²¹ МУИС, ШУС, ИБАСТ

үзэгдлийг дүрслэх хэлний уран яруу хэрэглүүр юм. Бэлгэдэл нь утга шилжүүлэх ёсны боловсорсон дээд хэлбэр бөгөөд уран зохиолд өргөн хүрээтэйгээр улам нарийссан хэлбэрээр хэрэглэгдсээр байна. Бэлгэдэн илэрхийлж байгаа дүр нь зохиолчийн илэрхийлэх эцсийн зорилгод нийцсэн үед өөрөөр хэлбэл зориудаар, санаатайгаар энэ аргыг сонгож авч...” (Байгалсайхан, 1998, хууд. 141) дүрээ тодотгон илэрхийлэх нь уран зохиолын нэгэн арга юм. Уран сайхны бэлгэдэл дүрийн шинж чанар нь түүнийг тайлбарлах, ухан ойлгох сэтгэлгээний талаасаа хандахыг шаарддаг учраас уран дүрийн хэрэглүүрийн нарийн хэлбэр юм. Бодит сэтгэхүйтэй холбох нарийн үйл ажиллагаа бөгөөд тухайн зүйлийн уялдаа холбоо, харилцан шүтэлцээнд тулгуурлан шууд ба шууд бус утгаар нь хүлээн авч болох юм. Бэлгэдлийг нь олон янзын зорилгоор хам сэдвийн хүрээнд хэрэглэж, зохиолч өөрийн уран сэтгэмж, шинэ санаа, үзэл бодол зэргээ далд утга хэлбэрээр илэрхийлэх нь түгээмэл хийгээд барууны уран зохиолд хэрхэн ашигласан туршлагыг харуулахыг зорьсон.

“Бэлгэдэл бол далд утгыг, бодит хэрэглээг ч агуулж байдаг. Бэлгэдэл бол оюун санааны бүтцийн бүтвэр нь юм. Тийм учраас сэтгэцийн бүхий л талыг шавхан сэтгэл хөдлөлийн загвар болж байдаг” (Дулам, 1999, хууд. 7) учраас бэлгэдлийг анхааран үзэж, орчуулгад тусгадаг. Иймээс бэлгэдлийн мөн чанарыг оновчтой орчуулгад тусгах нь орчуулагчаас ур чадвар, мэдрэмж, туршлага шаардсан ажил төдийгүй орчуулгын ажлын чанар чансаа, үнэлэмжид шууд нөлөөлдөг өндөр шалгууруудын нэг юм.


Бэлгэдлийн далд утгыг үл ухан, эсвэл эс хайхарсан тохиолдолд дүрийн дүр дүрслэл, өгүүлэмж алдахад хүрдэг. Ийм жишээ орчуулгын бүтээлд цөөнгүй тохиолддог билээ. Тэр тусмаа ёс уламжлал, шашин шүтлэг ялгаатай ард түмний бэлгэдлийн талаарх ойлголт ч зөрүүтэй байх нь түгээмэл билээ. Тэгвэл үүнийг орчуулгад хэрхэн буулгасан туршлага сургамжийг харьцуулан, задлан шинжлэх нь орчуулгын онол практикт тустай.

Т.Драйзер зохиолдоо шашин, од гараг, тоо, амьтан, ахуйн зэрэг нэлээд олон бэлгэдэл ашигласан бөгөөд тооны болон шашны бэлгэдлээр зохиолын гол баатруудын дүрийг хэрхэн тодотгон харуулж, зохиолын агуулга, үзэл санаагаа илэрхийлснийг толилуулж байна.

1. ШАШНЫ БЭЛГЭДЭЛ

“Шашны билэгзүй²² нэрлэж буй ойлголт, нэрлэгдэж буй зүйлийн адилтгал зүйрлэлээр дотоод холбоонд үндэслэгддэг” (Уеллек Р, 1998, хууд. 255) гэдэг нь бэлгэдлийн мөн чанарыг тодруулж байна. Библийн сургаалаас улбаатай хонь, хонины тухай эшлэлийг цөөнгүй ашигласан нь шашны нөлөө уран зохиолд нэлээд чухал байр суурь эзэлж байсныг харуулдаг. Тухайн үеийн хүнд хэцүү нөхцөл, амьдралын саад бэрхшээлийг даван туулахад энэхүү шашны бэлгэдэл хэчнээн чухал үүрэгтэй дараах жишээнүүдээс харж болно.

²² Уеллек Р, У. О. (1998). *Уран зохиолын онол*. Улаанбаатар: Хэвлэлийн газар. Уг номд “билэгзүй” гэж бичсэн тул энэ бичлэгээр нь авсан болно.



Хонины бэлгэдэл

Жишээ:1

“He keepeth His creatures whole,” was not written of beasts alone. Carrie was unwise, and, therefore, like the sheep in its unwisdom, strong in feeling. (Dreiser, Sister Carrie, 1982, p. 52)

“Бурхан, бүтээсэн амьтдаа бүтнээр хадгалдаг гэсэн үг гагцхүү амьтадад хамаарах бишээ. Керри ухаан сууж, дол цохиогүй байсан ч гэлээ ухаангүй аймгийнхаа доторх хонь лугаа адил байж зөн ихтэй байж... (Т.Драйзер, Керри эгч, 1983, хууд. 67)

Жишээ:2

Whether it be the tinkle of a lone sheep bell o'er some quiet landscape, or the glimmer of beauty in sylvan places, or the show of soul in some passing eye, the hearth knows and makes answer, following. (Dreiser, Sister Carrie, 1982, p. 400)

Намуун бэлчээрт идээшлэх хонины хүзүүн дэх хонхны дуу жингэнэсэн ч, аглаг хээр нутгийн гоо сайхан гялалзлаа ч, зуурдын тааралдах нүдний дулаан харц ч байлаа хүний зүрх гэгч мэдрэгч даган баясаж хариу болгодог ажээ. (Т.Драйзер, Керри эгч, 1983, хууд. 491)

Жишээ:3

To him these were ignorant and commonplace, poor sheep in a driver's hand.

“Poor devils,” he thought, speaking out of the thoughts and feelings of a bygone period of success. (Dreiser, Sister Carrie, 1982, p. 327)

Бас тэд дэндүү бүдүүлэг аминдаа арчаагүй бусдын эрхэнд дөртэй үхэр шиг явдаг улс мэт санагджээ. Урьд өөдрөг явахдаа иймэрхүү хүмүүсийг тоодоггүй байсанчлан “муусайн новинууд” гэж бодлоо. (Т.Драйзер, Керри эгч, 1983, хууд. 402)

Жишээ 1,2-т хонийг байгаль дэлхий, бурхан бүтээгч, хүнтэй холбон зөн совин, мэдрэмжээр дамжуулан номхон даруу, хүлцэнгүй амьтан гэдгийг дүрсэлжээ. Хүн байгалийн амьтан учраас хэчнээн гэгээрч хөгжсөөр байвч байгаль дэлхийд захирагдан байх болно гэсэн далд санааг илэрхийлсэн. Барууныхан хонийг Библийн сургаалтай холбон “эзний үгийг дуулгавартай дагагч” гэж хүлээн авдаг. Иймээс ч номхон даруу зан төлөв байдлыг бэлгэддэг шашны бэлгэдлийн уламжлалтай холбоотой бөгөөд энэ нь шууд ойлгогдож байна. Бэлгэдлийг зөв ухан, танин мэдсэнээр “ухаангүй аймгийнхаа доторх хонь, хонины хүзүүн дэх хонхны дуу” гэсэн үгчлэн орчуулсан ажээ. Өөрөөр хэлбэл Керригийн номхон хүлцэнгүй байдлыг илэрхийлэх хэрэглүүр болж байна.

Жишээ 3-т “Poor sheep in a driver's hand-дөртэй үхэр шиг” гэж дүйцүүлэн орчуулсан нь уран яруу орчуулга төдийгүй уран зохиолын орчуулгын шаардлагад бүрэн нийцсэн мэт боловч бэлгэдэл зүй ба шашны бэлгэдлийн талаас нарийвчлан үзвэл учир дутагдалтай бөгөөд харин шууд хоньтой холбон орчуулбал оновчтой юм. Монгол хэлэнд ч гэсэн ноомой даруу, хүлцэнгүй дорой байдлыг

хониор илэрхийлдэг тул “*номхон хонь шиг*” гэдэг түгээмэл зүйрлэлээр орчуулсан бол бэлгэдлийн далд утгыг илүү тодруулах байсан. Хэдийгээр энгийн мэт боловч бэлгэдлийн далд утгыг орхигдуулсан нь орчуулгын алдаа болсон.


Мөн номхон даруу, хүлцэнгүй байдлыг хониор дүрсэлсэн нь шашны бэлгэдэл төдийгүй соён гэгээрүүлэх, дотоод сэтгэл зүйд нөлөөлөх хүчтэй хэрэгсэл байсныг эдгээр жишээ харуулж байна.

2.ТООНЫ БЭЛГЭДЭЛ

Гурвын тооны бэлгэдэл

Өрнийн улс орнуудад тооны бэлгэдлийг янз бүрээр хүлээн авдаг. Тооны тухай сургаалыг үндэслэгч Пифагорын “дэлхий ертөнц тооны хүчинд тулгуурладаг”²³ гэсэн үзлийг баримтлагчид тооны шинж чанарыг таньж мэдэхийг чухалд тооцсоор иржээ.

“3”-ын тоог гүн ухаан, шашны сургаалын үүднээс гурван хэлбэр, гурван цагийн нэгдэл, төрөх, амьдрах, үхэхийн тойрог гэх зэргээр авч үзсэн байдаг. Христийн шашинд Гэгээн гурвал нь эцэг, хүү, ариун сүнс гэсэн ойлголт түгээмэл тархсан бөгөөд азын тоо, амжилтын тоо гэдэг.



*His bank was the **Third National** of Philadelphia, located in that center of all Philadelphia and indeed, at that time,...* (Dreiser, Financier, 1967, p. 6)

*Түүний ажиллаж байсан Филадельфийн **Гуравдугаар Банк** тэр үед бүх америкийн мөнгөн санхүүгийн төв гэж тоологдож байсан албаны хороололд байрлаж байжээ.* (Т.Драйзер, Санхүүч, 1973, хууд. 8)

*Cowperwood started in the note brokerage business with a small office at No. 64 South **Third Street**, where he very soon had the pleasure of discovering that his former excellent business connections remembered him.* (Dreiser, Financier, 1967, p. 53)

*Үүний урьд ажил төрлийн сайн холбоо тогтоосон Өмнөд **Гуравдугаар Гудамжны** 64 ноймрын байшинд конторлодог жижигхэн албан газар вексель тооцооны ажил хийх болсондоо Фрэнк баяртай байлаа.* (Драйзер, 1977)

*As he sat at his desk late that afternoon in his office looking out into **Third Street**, where a hurrying of brokers, managers, and anxious depositors still maintained,...* (Dreiser, Financier, 1967, p. 444)

²³ <https://updown.mn/3701.html>

Бичгийн ширээнийхээ ард суугаад цонхоороо харвал **Гуравдугаар Гудамжаар** биржийн зууч, төлөөний хүмүүс, тэвдэн балмагдсан хувь нийлүүлэгчид мөн л хөлхөлдсөөр байна. (Т.Драйзер, Санхүүч, 1973, хууд. 552)

*He with Simpson and Butler made up the **Big Three**.* (Dreiser, Financier, 1967, p. 88)

Симпсон, Батлер тэр гурав **“Гурван мундгийн”** бүрэлдэхүүнд оржээ. (Т.Драйзер, Санхүүч, 1973, хууд. 109)

*Thomas Wycroft, last of this useful but minor **triumvirate**, was a tall, lean man, candle-waxy, hollow eyed, gaunt of face, pathetic to look at physically, but shrewd.*

*... he had managed to make some money vi this **triumvirate** of which Strobik wqas ringleader, and which was engaged in variuos peculiar businesses which will now be indicated.* (Dreiser, Financier, 1967, p. 91)

Томас Вайкрофт бол цайвар цонхигор царай, хөнхөр нүдтэй, өндөр туранхай хүн бөгөөд гаднах байдал нь доождоогүй боловч ухаан мулгуу биш, тэр **“гурвын холбоотны”** сүүлчийн гишүүн юм.

... Тэгээд дараа өгүүлэгдэх олон янзын нэлээд өвөрмөц хэлбэрийн ажил эрхэлсэн Стробикийн удирдсан тэр **“гурвын холбоонд”** оролцсоны ачаар бага зэрэг хөрөнгөжиж чадлаа. (Т.Драйзер, Санхүүч, 1973, хууд. 111)

"Convict number 3633," Kendall called to a clerk, handing him at the same time a yellow slip of paper on which was written Cowperwood's full name and his record number, counting from the beginning of the penitentiary itself. (Dreiser, Financier, 1967, p. 384)

3633 номерын хоригдол гэж хэлээд Каупервудын овог нэр, бас тэр гяндангийн анх байгуулагдсан өдрөөс эхлэн тоолсон дэс дугаарт номер тавьсан жижиг шар цаасыг нэгэн бичигч хүнд өгөв. (Т.Драйзер, Санхүүч, 1973, хууд. 480)

Зохиолч Каупервуд хувьд ажил үйлс, санхүү мөнгөний ажлаа амжилттай явахыг бэлгэдэн “3”-ын тооны бэлгэдлийг ашигласан. Эцэг Хенри Каупервуд **Гуравдугаар Банкинд** ажиллаж, Фрэнк Каупервуд **Гуравдугаар Гудамжинд** ажиллаж, бяцхан хүү Каупервуд **13** настайдаа анхны арилжаагаа хийсэн нь утга учиртай. Каупервуд Симпсон, Батлер, Каупервуд нар өөрсдийгөө **“Гурван мундаг”** хэмээн нэрлэж буй нь тохиолдлын санаандгүй хэрэг биш ажээ. Мөн Стинер, Вайкроф нартай нэгдэн **“гурвын холбоотон”** гэгдэж улс төрийн үйл хэрэгт оролцон улмаар хөрөнгөжиж, мандан гийх үе байсан ч хүний амьдралын жамаар унаж босож, өгсөн уруудаж явсан. Түүний замнал дардан байгаагүй бөгөөд хийсэн хэргийнхээ ялыг үүрэн шоронд орж, хоригдол болоход түүний дугаар **3633** байсан нь эрх чөлөөгүй хоригдож байхад ч гэсэн аз хийморь ивээхийг бэлгэдсэн биз. Өөдлөн мандаж алдар нэртэй үед ч, уруудан доройтон унаж босох үед ч “3” тоо түүнтэй хамт явсаар байгаа нь бэлгэдлийн мөн чанарыг илэрхийлсээр байх ажээ.

Фрэнк Каупервуд бол санхүү мөнгөний тал дээр мэргэжсэн төдийгүй гүйлгэн ухааныхаа ачаар амжилтад хүрч, эд баялаг хөрөнгө мөнгөний амт шимт, үр өгөөж, хүч чадлыг мэдэрсэн нэгэн. Түүний амжилт, эд мөнгө дагалдаж байсан нь “аз, амжилтыг бэлгэддэг 3”-ын тооны нууц байж болох юм. Тиймээс эдгээр “гурвын тоо”-ны бэлгэдлийг сонгон хэрэглэсэн нь гол дүрийн өсөн дэвжин, урагш тэмүүлэх далд хүч гэдгийг харж болно.

Зохиолч тооны болон шашны бэлгэдлийг сонгон ашигласан нь тухайн зүйлийн утга санааг шууд ба шууд бусаар дамжуулах, ухааруулан ойлгуулах арга ажээ. Бэлгэдэл нь тухайн ард түмний оюун санаанд чухал байр суурь эзэлдэг уран дүрийн чухал хэрэглүүр болсоор ирсэн юм.

Дүгнэлт

Бэлгэдэл нь тухайн ард түмний оюун санаа, сэтгэлгээг таньж мэдэх уран зохиолын хэрэгсэл юм. Тоо болон шашны бэлгэдлийн талаар судалгаа хийснээр тухайн зохиолын бэлгэдлийн мөн чанар, далд утга, учир шалтгаан, харилцан уялдаа холбоог алдагдуулахгүйгээр үнэн зөв орчуулах боломжтой гэдгийг энэхүү орчуулгын туршлага, сургамж харуулж байна. Бэлгэдэл нь зохиолчийн уран сэтгэмж, шинэ санаа, дүр дүрслэлийн хийсвэр болон бодит сэтгэлгээний илэрхийлэл төдийгүй аж амьдрал, зан заншил, шашин соёлын ялгаа, онцлог зэргийг тусгадаг уран зохиолын орчуулгын судлагдахуун учраас учир холбогдлыг нь анхааран үзэж орчуулгад буулгах нь чухал билээ.

Ном зүй

Англи хэлээр:

Dreiser, T. (1967). *Financier*. New York: Thomas Y.Crowell company.

Dreiser, T. (1982). *Sister Carrie*. Bantam Classic Edition.

Монгол хэлээр:

Байгалсайхан, С. (1998). *Уран дүрийн онолын лекцүүд*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Драйзер, Т. (1977). *Мундаг эр*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Т.Драйзер. (1973). *Санхүүч*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Т.Драйзер. (1983). *Керри эгч*. Улаанбаатар : Улсын Хэвлэлийн газар.

Дулам С. (1999). *Монгол бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Адмон ХК.

Дулам С. *Монгол домог зүйн дүр*. Дэд дэвтэр УБ., 1989.

Уеллек Р, У. О. (1998). *Уран зохиолын онол*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.